



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/08

Дэлгэрмөрөн

“Цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижилт”-ийн  
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
Үнэлгээний хороо байгуулах тухай

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх сумын төвийн “Цэцэрлэгт хүрээлэнгийн доторх тохижилтийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Ч.Дамдинсандив (Хөдөлмөр эрхлэлт, халамж хариуцсан мэргэжилтэн)

Гишүүдэд: О.Баяржаргал (Сан, Соёл хариуцсан нягтлан бодогч)

С.Сэргэлэн (Насан туршийн боловсролын багш)

Ж.Дэлгэрмаа (Иргэний төлөөлөл)

Нарийн бичгийн дарга: Г.Золбоо (Бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Тендер шалгаруулалтын холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авилга, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг тендерийн үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сэрдагва)-д даалгасугай.



ДАРГА

С.СУМЪЯАБАЗАР

Zahiramj -2022 он

642201001